

БАТЛАВ.  
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ  
ДАРГА Ц.ШАРАВЖАМЦ



# МОНГОЛЫН БҮХ АРД ТҮМНИЙ СПОРТЫН XV НААДМЫН НЭГДСЭН ЗААВАР

Улаанбаатар хот  
2022 он

**АГУУЛГА:**

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ
2. НААДМЫН ХӨТӨЛБӨР
3. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА
4. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ
5. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХУГАЦАА
6. ТАМИРЧДЫН ЭРХИЙН БАТАЛГААЖИЛТ
7. ЦАХИМ БҮРТГЭЛ
8. САНХҮҮЖИЛТ
9. ДҮГНЭХ АРГАЧЛАЛ
10. СПОРТЫН ТӨРӨЛ
11. ГАДААД УЛСАД ЗОХИОГДОХ ТЭМЦЭЭН
12. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам”-ын 2.1 хэсэг, Засгийн газрын 2021 оны 268 дугаар тогтоолыг үндэслэн Монголын бүх ард түмний спортын наадмыг зохион байгуулахад энэ зааврыг баримтална.

1.2. Монголын бүх ард түмний спортын наадмын /цаашид наадам гэх/ зорилго нь олон улсын стандартад нийцсэн, улсын хэмжээнд өргөн дэлгэр хөгжсөн спортын төрлүүдээр зохион байгуулах, дотоодын өрсөлдөөнийг дэмжих, тив, дэлхийн тэмцээн, наадамд өрсөлдөх тамирчдын ур чадварыг нэмэгдүүлэхэд оршино.

1.3. Монголын бүх ард түмний спортын наадамд дараах зарчмыг баримтална.

- **ШИЛДЭГ:** Улсын хэмжээнд зохион байгуулагдах наадмын оролцогчид нь спортын төрөл тус бүрээс шалгарсан тамирчид байна.

- **ХҮМҮҮНЛЭГ:** Тамирчдын тэгш боломж, жендерийн тэгш байдлыг хангана.

- **ХҮРТЭЭМЖТЭЙ:** Улсын хэмжээнд спортоор хичээллэгсдийн бүх нийтийн оролцоог хангаж, өндөр зэрэглэлийн тамирчдыг бэлтгэх, иргэн бүр оролцох боломжийг бүрдүүлнэ.

- **ШУДАРГА:** Спортын ёс зүй, ил тод шүүлт, цэвэр шударга өрсөлдөөн, зохион байгуулалтын зарчмыг эрхэмлэнэ.

- **ТОГТВОРТОЙ:** Нийгэмд эерэг нөлөөлөл үзүүлж, үндэсний бахархлыг нэмэгдүүлэх, иргэдийг насан туршдаа идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх урам зоригийг төрүүлнэ.

1.4 Наадмын хөтөлбөрт багтсан спортын төрлүүд, тэмцээнд оролцогч байгууллага, баг, тамирчдад тавигдах шаардлага, тэмцээний удирдлага зохион байгуулалт, санхүүжилт, тайлан, дүгнэх арга аргачлалыг багтаасан болно. Үүнд:

## ХОЁР. НААДМЫН ХӨТӨЛБӨР

2.1 Монголын бүх ард түмний спортын наадам нь зуны Олимпын 20, Паралимпын 3, Дифлимпын 2 нийт спортын 25 төрлөөр зохион байгуулагдана.

Шигшээ тэмцээний медалийн тоо /багц/, тамирчдын тоо:

Спортын төрөл	Медалийн тоо (багц)				Тамирчдын тоо /дээд тоо/		
	эрэгтэй	эмэгтэй	Баг	Бүгд	эрэгтэй	эмэгтэй	Бүгд
<i>Байт харваа</i>	1	1	2	4	120	120	240
<i>Бокс</i>	8	5	-	13	240	150	390
<i>Буудлага</i>	4	4	4	12	180	180	360
<i>Волейбол</i>	1	1	-	2	192	192	384
<i>Гимнастик /аэробик/</i>	1	1	3	5	150	150	300
<i>Даам</i>	1	1	-	2	120	120	240
<i>Дугуй</i>	1	1	3	5	60	60	120
<i>Жүдо бөх</i>	7	7	-	14	210	210	420
<i>Пауэрлифтинг</i>	7	4	-	11	210	120	330
<i>Сагсан бөмбөг 5x5</i>	1	1	-	2	160	160	320

Сагсан бөмбөг 3x3	1	1	-	2	120	120	240
Самбо	7	7	-	14	210	210	420
Спортын бүжиг	-	-	2	2	60	60	120
Таеквондо	6	6	-	12	120	120	240
Хөл бөмбөг	1	-	-	1	240	-	240
Хөнгөн атлетик	11	11	4	26	240	240	480
Хүндийн өргөлт	7	7	-	14	210	210	420
Чөлөөт бөх	6	6	-	12	180	180	360
Шатар	1	1	-	2	30	30	60
Ширээний теннис	1	1	3	5	150	150	300
<b>нийт</b>	<b>73</b>	<b>66</b>	<b>21</b>	<b>160</b>	<b>3202</b>	<b>2782</b>	<b>5984</b>
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын төрөл:							
Паралимп							
Пара жүдо бөх	4	4	-	8	Нээлттэй		
Пара хөнгөн	6	5		10			
Суугаа волейбол	1	1	-	2			
Хонхот бөмбөг	1	1	-	2			
Дифлимп							
Сагсан бөмбөг	1	1	-	2	Нээлттэй		
Ширээний теннис	1	1	-	2			
<b>нийт</b>	<b>14</b>	<b>13</b>	<b>-</b>	<b>26</b>			
Гадаадад улсад зохиогдох спортын төрөл: /Ази, Америк, Европ/							
Сагсан бөмбөг	-	-	6	6	Наадмын хүрээнд		
Волейбол	-	-	6	6			
Хөл бөмбөг	-	-	3	3			
<b>нийт</b>			<b>15</b>	<b>15</b>			
<b>Бүгд</b>	<b>88</b>	<b>79</b>	<b>36</b>	<b>202</b>			

2.2 Наадмын хөтөлбөрийн хүрээнд гадаадад амьдарч буй Монгол иргэдийн дунд спортын зарим төрлийн тэмцээнийг наадмын Зохион байгуулах хороо, Гадаад харилцааны яам, тухайн улс дахь Элчин сайдын яам, Консулын газар, Монголчуудын спортын төрийн бус байгууллагууд хамтран Монгол иргэдийн оролцоог хамгийн ихээр хангах бололцоотой улс, хотыг сонгож, баталсан заавар, удирдамжийн дагуу зохион байгуулна.

## ГУРАВ. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

### 3.1. Байгууллагад тавигдах шаардлага:

3.1. Наадмын оролцогч нь 21 аймаг, 9 дүүрэг байна.

3.1.1. спортын клуб, зэвсэгт хүчин, онцгой байдал, хууль сахиулах байгууллагын спорт хороо нь тухайн засаг захиргааны нэгж дэх байршлын дагуу тухайн аймаг, дүүрэгт харьяалагдана.

3.1.2. зэвсэгт хүчин, онцгой байдал, хууль сахиулах байгууллагын спорт хороо, спортын клуб нь баг, тамирчдаа тухайн засаг захиргааны нэгжийн анхан шатны тэмцээнд оролцуулсан байна.

### 3.2. Тамирчинд тавигдах шаардлага:

3.2.1. Монгол Улсын иргэн байна.

3.2.2. тухайн спортын холбооны олон улсын дүрэмд заасан насны ангиллаар оролцоно.

3.2.3. тамирчин анхан шатны тэмцээнд бүртгэгдсэн цахим бүртгэлээр бүсийн болон шигшээ тэмцээнд оролцоно.

3.2.4. оролцогчийн гэрээ байгуулсан байна. / цахим гэрээ /

## **ДӨРӨВ. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ**

4.1. Наадмын оролцогч тамирчдыг дараах үе шатаар сонгон шалгаруулна.

4.1.1 сум, хороо

4.1.2 аймаг, дүүрэг

4.1.3 бүс

4.1.4 шигшээ тэмцээн

4.2. Тамирчин өөрийн сонголтоор хичээллэж буй клуб, харьяалагдах байгууллага, засаг захиргааны нэгжийн аль нэг анхан шатны тэмцээнд оролцох сонголтоо хийж болно.

## **ТАВ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХУГАЦАА**

5.1. Анхан шатны тэмцээнийг аймаг, дүүргийн Зохион байгуулах хороо, Биеийн тамир, спортын газар /хороо/-д спортын холбоодтой хамтран 2022 оны 03 дугаар сарын 21-нээс 04 дүгээр сарын 28-ны өдрүүдэд зохион байгуулна.

5.2. Бүсийн тэмцээнийг бүсийн төвийн Зохион байгуулагч, Биеийн тамир, спортын газар /хороо/-д, спортын салбар холбоод волейбол, сагсан бөмбөг 5х5, хөл бөмбөгийн спортын төрлөөр 2022 оны 05 дугаар сарын 11-20-ны өдрүүдэд товлогдсон бүсийн төвүүдэд зохион байгуулна.

5.3. Шигшээ тэмцээнийг наадмын Зохион байгуулах хороо, Биеийн тамир, спортын улсын хороо, Спортын холбоод 2022 оны 06 дугаар сарын 13-19-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулна.

5.4. Гадаадад амьдарч буй Монгол иргэдийн дунд зохиогдох спортын тэмцээний товыг наадмын шигшээ тэмцээний дурдсан хугацаанд багтаан зохион байгуулна.

## **ЗУРГАА. ТАМИРЧДЫН ЭРХИЙН БАТАЛГААЖИЛТ**

6.1. Зохион байгуулах хороо шилдэг, хүмүүнлэг, хүртээмжтэй, шударга, тогтвортой үзэл баримтлалыг хангаж, олон улсын спортын холбооны дүрмийн дагуу анхан шат, бүсийн тэмцээнээс шалгарсан баг, тамирчдад наадмын шигшээ тэмцээнд оролцох эрхийг олгож, баталгаажуулна.

6.2. Волейбол, сагсан бөмбөг 5х5, хөл бөмбөгийн спортын төрлүүдийн анхан шатны тэмцээнээс 1 дүгээр байрт шалгарсан баг бүсийн тэмцээнд оролцох эрхийг олгож баталгаажуулна.

6.3. Зохион байгуулах хороо шигшээ тэмцээний эрхийн баталгаажилтыг спортын төрөл тус бүрийн тэмцээн эхлэх хугацаанаас 10 хоногийн өмнө баталгаажуулна.

6.4. Эрх нь баталгаажсан баг, тамирчин хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шигшээ тэмцээнд оролцох боломжгүй тохиолдолд спортын төрөл бүрийн эрхийн эцсийн баталгаажилт хийгдэхээс 6 хоногийн дотор Зохион байгуулах хороонд мэдэгдэнэ.

6.5. Зохион байгуулах хорооноос дараагийн эрэмбэлэгдсэн баг, тамирчинд 4 хоногийн дотор эрхийг шилжүүлэн баталгаажуулна.

## ДОЛОО. ЦАХИМ БҮРТГЭЛ

### 7.1. Тоон мэдүүлэг

Анхан шатны тэмцээний баг, тамирчдын тоон мэдүүлгийг цахимаар авна. Тоон мэдүүлгийн бүртгэлийн систем 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдөр нээгдэж, 02 дугаар сарын 20-ны өдрийн 22:00 цагт хаагдана.

Тоон мэдүүлгийг батлагдсан загварын дагуу [games@sport.gov.mn](mailto:games@sport.gov.mn) цахим хаягаар файлаар ирүүлнэ.

### 7.2. Нэрэн мэдүүлэг

7.2.1 Анхан шатны тэмцээний баг, тамирчдын нэрэн мэдүүлгийг цахимаар авна. Нэрэн мэдүүлгийн бүртгэлийн систем 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдөр нээж 03 дугаар сарын 13-ний өдрийн 22:00 цагт хаана.

7.2.2 Бүсийн тэмцээний нэрэн мэдүүлгийн бүртгэлийн систем 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр нээгдэж, 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 22:00 цагт хаагдана.

7.2.3 Шигшээ тэмцээнд оролцох багийн төрлийн тамирчдын цахим бүртгэлийн 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 06:00 цагаас 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 22:00 цагт гаргасан байна.

7.3. Аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороод цахим бүртгэлд дараах оролцогчдыг бүртгүүлнэ. Үүнд:

- 7.3.1. тамирчин
- 7.3.2. дасгалжуулагч
- 7.3.3. багийн ахлагч
- 7.3.4. менежер
- 7.3.5. эмч
- 7.3.6. сэтгэл зүйч
- 7.3.7. хоол зүйч
- 7.3.8. массажист

7.4. Зохион байгуулагчийн цахим бүртгэлд дараах ажилтныг бүртгэнэ. Үүнд:

- 7.4.1. ерөнхий шүүгч
- 7.4.2. шүүгч
- 7.4.3. тэмцээний нарийн бичиг
- 7.4.4. зохион байгуулагч
- 7.4.5. сайн дурын ажилтан
- 7.4.6. холбооны ерөнхийлөгч
- 7.4.7. холбооны ерөнхий нарийн бичгийн дарга
- 7.4.8. албаны ажилтан
- 7.4.9. хүндэт зочин
- 7.4.10. хэвлэл, мэдээллийн ажилтан
- 7.4.11. бусад

7.5. Наадмын Зохион байгуулах хорооноос баталсан цахим бүртгэлийн зааварчилгааг оролцогч байгууллагуудад 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс өмнө хүргүүлж тухай бүрд сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.

7.6. Зохион байгуулах хорооны цахим бүртгэлийн ажлын хэсэг цахим бүртгэлийн бүхий л үйл ажиллагааг хариуцаж, хяналт тавьж ажиллана.

7.7. Цахим бүртгэлтэй холбоотой мэдээллийг [www.sport.gov.mn](http://www.sport.gov.mn) цахим хуудсанд байршуулна.

## НАЙМ. САНХҮҮЖИЛТ

8.1. Наадмын спортын төрлүүдийн анхан шатны тэмцээний зохион байгуулалтад шаардагдах дараах зардлыг тухайн аймаг, дүүргийн Зохион байгуулах хороо, Биеийн тамир, спортын газар, хороод хариуцна. Үүнд:

- 8.1.1. тэмцээний заал, талбай, үзелийн хөлс
- 8.1.2. байгууллага, баг тамирчид, дасгалжуулагчдад олгох өргөмжлөлийн зардал;
- 8.1.3. тэмцээний шүүгчийн ажлын хөлс;
- 8.1.4. халдвар хамгаалал, эмнэлгийн яаралтай болон анхны тусламж үйлчилгээний зардал;
- 8.1.5. мэдээлэл, сурталчилгааны хөлс
- 8.1.6. тээвэр, шатахууны зардал
- 8.1.7. тэмцээний нээлт, хаалтын арга хэмжээний зардал

8.2. Аймаг, дүүргийн Зохион байгуулах хороо, Биеийн тамир, спортын газар, хороод бүсийн болон шигшээ тэмцээнд баг тамирчдаа оролцуулахад шаардагдах дараах зардлыг хариуцна. Үүнд:

- 8.2.1. тэмцээнд оролцох баг тамирчдын бэлтгэл, байр, хоол, бэлтгэлийн хувцас, хэрэгслийн зардал;
- 8.2.2. тээвэр, шатахууны зардал;
- 8.2.3. халдвар хамгаалал, эмнэлгийн яаралтай, анхны тусламж үйлчилгээний зардал;

8.3. Бүсийн тэмцээний зохион байгуулалтад шаардагдах зардлыг Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороо, Зохион байгуулах хороо хариуцна. Үүнд:

- 8.3.1. тэмцээний заал, талбай, үзелийн хөлс;
- 8.3.2. тэмцээний шүүгчийн ажлын хөлс, томилолтын зардал;
- 8.3.3. тээвэр, шатахууны зардал

8.4. Наадмын шигшээ тэмцээний зохион байгуулалтад шаардагдах зардлыг Засгийн газрын тохируулагч агентлаг, Биеийн тамир, спортын улсын хороо, Зохион байгуулах хороо хариуцна. Үүнд:

- 8.4.1. тэмцээний заал, талбайн түрээс, үзелийн хөлс;
- 8.4.2. байгууллага, баг тамирчид, дасгалжуулагчдад олгох мандат, цом, медаль, өргөмжлөлийн зардал;
- 8.4.3. тэмцээний шүүгчийн ажлын хөлс;
- 8.4.4. халдвар хамгаалал, эмнэлгийн яаралтай, анхны тусламж үйлчилгээний зардал;
- 8.4.5. допингийн зардал;
- 8.4.6. зохион байгуулах хорооны үйл ажиллагааны зардал;
- 8.4.7. мэдээлэл, сурталчилгааны зардал
- 8.4.8. тээврийн үйлчилгээ, шатахууны зардал
- 8.4.9. нийтлэг үйлчилгээний зардал
- 8.4.10. халдвар хамгаалалт, ариутгалын зардал
- 8.4.11. заал талбайн тохижилт
- 8.4.12. хэвлэл, эх бэлтгэлийн зардал
- 8.4.13. сайн дурын ажилтны зардал
- 8.4.14. нээлт, хаалтын арга хэмжээний зардал

8.5. Шигшээ тэмцээнд амжилттай оролцож, медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчдад Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 173 тогтоолоор батлагдсан “Үндэсний хэмжээний тэмцээн, наадамд амжилттай оролцож медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагчийг шагнаж урамшуулах, мөнгөн шагнал олгох журам”-ын дагуу мөнгөн шагналаар шагнаана.

8.6. Шигшээ тэмцээнд амжилттай оролцсон 6 аймаг, 3 дүүргийн Зохион байгуулах хороог цом, өргөмжлөлөөр шагнаана.

8.7. Шигшээ тэмцээний амжилттай зохион байгуулсан шилдэг 5 спортын холбоог цом, мөнгөн шагнал, өргөмжлөлөөр шагнаана.

8.8. Шигшээ тэмцээнд баг, тамирчдаа амжилттай бэлтгэн оролцуулсан Зэвсэгт хүчин, онцгой байдлын болон хууль сахиулах байгууллагын 3 спорт хороо, 3 спортын клубийг тус тус цом, өргөмжлөлөөр шагнаана.

## ЕС. ДҮГНЭХ АРГАЧЛАЛ

9.1. Наадамд оролцогч байгууллагыг Олон улсын спортын наадмын дүгнэх аргачлалын дагуу медалийн чанараар дүгнэж байр эзлүүлнэ.

## АРАВ. СПОРТЫН ТӨРӨЛ

### 10.1. БАЙТ ХАРВАА:

#### Медалийн тоо /багц/

Эрэгтэй	Эмэгтэй	Баг	Бүгд
1	1	2	4
<i>70 метр Ганцаарчилсан</i>	<i>70 метр Ганцаарчилсан</i>	<i>70 метр-эрэгтэй 3, эмэгтэй 3,</i>	

Анхан шатны тэмцээнээс 1 дүгээр байр эзэлсэн баг, тамирчин шигшээ тэмцээнд оролцоно. 1 тамирчин ганцаарчилсан болон багийн төрөлд оролцож болно.

#### Тамирчдын тоо / шигшээ тэмцээн /

Эрэгтэй	Эмэгтэй	Баг	Бүгд
30	30	180	240

Тайлбар: Шигшээ тэмцээнд шалгаран оролцох тамирчдын тоо

Тэмцээний хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 14-17-ны өдрүүдэд зохион байгуулна.

Насны хязгаар: 2004 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш төрсөн 18 түүнээс дээш насны тамирчин оролцоно.

Эрх баталгаажих хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 04-13-ны өдрүүдэд баталгаажна.

### 10.2. БОКС

#### Медалийн тоо /багц/

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
8	5	13
<i>Ганцаарчилсан</i>	<i>Ганцаарчилсан</i>	<i>эрэгтэй 8 жин, эмэгтэй 5 жин</i>
<i>49-52кг, 52-57кг, 57-63кг, 63-69кг, 69-75кг, 75-81кг, 81-91кг, +91кг</i>	<i>48-51кг, 54-57кг, 57-60кг, 64-69, 69-75кг,</i>	

Анхан шатны тэмцээнээс 1 дүгээр байр эзэлсэн тамирчин шигшээ тэмцээнд оролцоно.



**Тамирчдын тоо /шигшээ тэмцээн /**

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
240	150	390

Тайлбар: Шигшээ тэмцээнд шалгаран оролцох тамирчдын нийт тоо

Тэмцээний хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 14-21-ний өдрүүдэд зохион байгуулна.

Насны хязгаар: 1982 оны оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2003 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд төрсөн 19-40 насны тамирчид оролцоно.

Эрх баталгаажих хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 04-11-ний өдрүүдэд баталгаажна.

**10.3. БУУДЛАГА****Медалийн тоо /багц/**

Эрэгтэй	Эмэгтэй	Холимог	Бүгд
4	4	4	12
<i>Ганцаарчилсан</i>	<i>Ганцаарчилсан</i>		
<i>10м хийн урт буу/гар буу, 25м гар буу/хурдан, 50м урт буу 3 байрлалд</i>			

Анхан шатны тэмцээнээс 1 дүгээр байр эзэлсэн баг, тамирчин шигшээ тэмцээнд оролцоно. 1 тамирчин ганцаарчилсан болон багийн төрөлд оролцож болно.

**Тамирчдын тоо /шигшээ тэмцээн /**

Эрэгтэй	Эмэгтэй	Баг	Бүгд
120	120	240	360

Тайлбар: Шигшээ тэмцээнд шалгаран оролцох тамирчдын нийт тоо

Тэмцээний хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 14-18-ны өдрүүдэд зохион байгуулна.

Насны хязгаар: 2006 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр төрсөн 16 түүнээс дээш насны тамирчид оролцоно.

Эрх баталгаажих хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 04-11-ний өдрүүдэд баталгаажна.

**10.4. ВОЛЕЙБОЛ****Медалийн тоо /багц/**

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
1	1	2
<i>Баг-12 тоглогч</i>	<i>Баг 12 тоглогч</i>	
<i>Хангайн бүс-3, Төвийн бүс-3, Баруун бүс-3, Зүүн бүс-3, Нийслэл-4 баг</i>		<i>эрэгтэй 16 баг, эмэгтэй 16 баг</i>

**Тамирчдын тоо / шигшээ тэмцээн /**

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
192	192	384

Тайлбар: Шигшээ тэмцээнд шалгаран оролцох тамирчдын нийт тоо

Тэмцээний хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 13-22-ны өдрүүдэд зохион байгуулна.

Насны хязгаар: 2004 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр төрсөн 18 түүнээс дээш насны тамирчид оролцоно.

Эрх баталгаажих хугацаа: Бүсийн тэмцээнээс шалгарсан эрэгтэй 16 баг, эмэгтэй 16 багийн эрх 2022 оны 06 дугаар сарын 04-11-ний өдрүүдэд баталгаажна.

## 10.5. ГИМНАСТИК /АЭРОБИК/

### Медалийн тоо

Эрэгтэй	Эмэгтэй	Баг	Холимог	Бүгд
1	1	2	1	5
<i>ганцаарчилсан</i>	<i>ганцаарчилсан</i>	<i>баг</i>	<i>хос</i>	
		бүжгийн төрөл 8 оролцогч		

Анхан шатны тэмцээнээс 1 дүгээр байр эзэлсэн баг, тамирчин шигшээ тэмцээнд оролцоно. 1 тамирчин ганцаарчилсан болон багийн төрөлд оролцож болно.

### Тамирчдын тоо / шигшээ тэмцээн /

Эрэгтэй	Эмэгтэй	Баг	Бүгд
30	30	240	300

Тайлбар: Шигшээ тэмцээнд шалгаран оролцох тамирчдын нийт тоо

Багийн төрөл: Аэробикийн бүжгийн багийн төрлөөр хүйс харгалзахгүй 8 тамирчин байна.

Тэмцээний хугацаа: Тэмцээний хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд зохион байгуулна.

Насны хязгаар: 2004 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр төрсөн 18 түүнээс дээш насны тамирчид оролцоно.

Эрх баталгаажих хугацаа: Шигшээ тэмцээнд оролцох тамирчны эрх 2022 оны 06 дугаар сарын 04-11-ний өдрийн дотор баталгаажна.

## 10.6. ДААМ

### Медалийн тоо /багц/

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
1	1	2
<i>Ганцаарчилсан</i>	<i>Ганцаарчилсан</i>	

Анхан шатны тэмцээнээс 1 дүгээр байр эзэлсэн тамирчин шигшээ тэмцээнд оролцоно.

### Тамирчдын тоо / шигшээ тэмцээн /

Эрэгтэй	Эмэгтэй	Баг	Бүгд
30	30	-	60

Тайлбар: Шигшээ тэмцээнд шалгаран оролцох тамирчдын нийт тоо

Тэмцээний хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулна.

Насны хязгаар: 2004 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр төрсөн 18 түүнээс дээш насны тамирчид оролцоно.

Эрх баталгаажих хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 05-13-ны өдрийн дотор баталгаажна.

## 10.7. ДУГУЙ

### Медалийн тоо /багц/

Эрэгтэй	Эмэгтэй	баг	Бөөн гараа	Бүгд
1	1	1	2	5
<i>Ганцаарчилсан</i>	<i>Ганцаарчилсан</i>	<i>Баг 4 хүн /ТТ/</i>	-	
<i>кросс коаунтри 30км,</i>	<i>кросс коаунтри 21км,</i>	<i>Застал замын эрэгтэй 50км,</i>	<i>эрэгтэй 150км, эмэгтэй 75км,</i>	

Анхан шатны тэмцээнээс 1 дүгээр байр эзэлсэн баг, тамирчин шигшээ тэмцээнд оролцоно. тамирчин ганцаарчилсан болон багийн төрөлд оролцож болно.

**Тамирчдын тоо /шигшээ тэмцээн /**

Эрэгтэй	Эмэгтэй	Баг, бөөн гараа	Бүгд
60	60	120	240

Тайлбар: Шигшээ тэмцээнд шалгаран оролцох тамирчдын нийт тоо

Тэмцээний хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 15-19-ний өдрүүдэд зохион байгуулна.

Насны хязгаар: 2003 оны 01 дүгээр сарын 01-ны өдөр төрсөн 19 түүнээс дээш насны тамирчид оролцоно.

Эрх баталгаажих хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 05-13-ны өдрийн дотор баталгаажна.

**10.8. ЖУДО БӨХ****Медалийн тоо /багц/**

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
7	7	14
Ганцаарчилсан	Ганцаарчилсан	
60кг, 66кг, 73кг, 81кг, 90кг, -100кг, +100кг	48кг, 52кг, 57кг, 63кг, 70кг, -78кг, +78кг	эрэгтэй 7, эмэгтэй 7 жин

Анхан шатны тэмцээнээс 1 дүгээр байр эзэлсэн тамирчин шигшээ тэмцээнд оролцоно.

**Тамирчдын тоо /шигшээ тэмцээн/**

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
210	210	420

Тайлбар: Шигшээ тэмцээнд шалгаран оролцох тамирчдын нийт тоо

Тэмцээний хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд зохион байгуулна.

Насны хязгаар: 2005 оны 01 дүгээр сарын 01-ны өдөр төрсөн 17 түүнээс дээш төрсөн тамирчин оролцоно.

Эрх баталгаажих хугацаа: Шигшээ тэмцээнд оролцох тамирчны эрх 2022 оны 06 дугаар сарын 04-11-ны өдрийн дотор баталгаажна.

**10.9. ПАУЭРЛИФТИНГ****Медалийн тоо /багц/**

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
7	4	11
-66кг, -74кг, -83кг, 93кг, -105кг, 120кг, +120кг,	-57кг, -57кг, 63кг, +63кг	эрэгтэй 7, эмэгтэй 4 жин
<i>классик штангтай суулт, хэвтээ шахалт, гар таталт</i>		

Анхан шатны тэмцээнээс 1 дүгээр байр эзэлсэн тамирчин шигшээ тэмцээнд оролцоно.

**Тамирчдын тоо / шигшээ тэмцээн /**

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
210	120	330

Тайлбар: Шигшээ тэмцээнд шалгаран оролцох тамирчдын нийт тоо

Тэмцээний хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 17-19-ний өдрүүдэд зохион байгуулна.

Насны хязгаар: 2004 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр төрсөн 18 түүнээс дээш төрсөн тамирчин оролцоно.

Эрх баталгаажих хугацаа: Шигшээ тэмцээнд оролцох тамирчны эрх 2022 оны 06 дугаар сарын 07-16-ны өдрийн дотор баталгаажна.

### 10.10. САГСАН БӨМБӨГ 5Х5

#### Медалийн тоо /багц/

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
1	1	2
<i>Баг 10 тоглогч</i>	<i>Баг 10 тоглогч</i>	
<i>Хангайн бүс-3, Төвийн бүс -3, Баруун бүс- 3, Зүүн бүс-3, Нийслэл-4</i>		<i>эрэгтэй16, эмэгтэй 16 баг</i>

#### Тамирчдын тоо /шигшээ тэмцээн/

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
160	160	320

Тайлбар: Шигшээ тэмцээнд шалгаран оролцох тамирчдын нийт тоо

Тэмцээний хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 14-21-ний өдрүүдэд зохион байгуулна.

Насны хязгаар: 2005 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр төрсөн 17 түүнээс дээш насны тамирчид оролцоно.

Эрх баталгаажих хугацаа: Шигшээ тэмцээнд оролцох тамирчны эрх 2022 оны 06 дугаар сарын 04-11-ний өдрийн дотор баталгаажна.

### 10.11. САГСАН БӨМБӨГ 3Х3

#### Медалийн тоо /багц/

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
1	1	2
<i>Баг 4 тоглогчтой</i>	<i>Баг 4 тоглогчтой</i>	

#### Тамирчдын тоо /шигшээ тэмцээн/

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
120	120	240

Тайлбар: Шигшээ тэмцээнд шалгаран оролцох тамирчдын нийт тоо

Тэмцээний хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 16-20-ны өдрүүдэд зохион байгуулна.

Насны хязгаар: 2005 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр төрсөн 17 түүнээс дээш насны тамирчид оролцоно.

Эрх баталгаажих хугацаа: Шигшээ тэмцээнд оролцох тамирчны эрх 2022 оны 06 дугаар сарын 06-13-ны өдрүүдэд баталгаажна.

### 10.12. САМБО БӨХ

#### Медалийн тоо /багц/

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
7	7	14
<i>Ганцаарчилсан</i>	<i>Ганцаарчилсан</i>	
<i>-58кг,-64кг,-71кг,-79кг,-88кг, -98кг, +98кг,</i>	<i>-50кг, -54кг, -59кг, -65кг,-72кг,-80кг, +80кг</i>	<i>эрэгтэй 7, эмэгтэй 7 жин</i>

Анхан шатны тэмцээнээс 1 дүгээр байр эзэлсэн баг, тамирчин шигшээ тэмцээнд оролцоно.

#### Тамирчдын тоо /шигшээ тэмцээн/

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
210	210	420

Тайлбар: Шигшээ тэмцээнд шалгаран оролцох тамирчдын нийт тоо

Тэмцээний хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд зохион байгуулна.

Насны хязгаар: 2004 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр төрсөн 18 түүнээс дээш төрсөн тамирчин оролцоно.

Эрх баталгаажих хугацаа: Шигшээ тэмцээнд оролцох тамирчны эрх 2022 оны 06 дугаар сарын 06-12-ны өдрүүдэд баталгаажна.

### 10.13. СПОРТ БҮЖИГ

#### Медалийн тоо /багц/

Хос	Бүгд
2	2
<i>Латин /С, Ч, Р, П, Ж/, Стандарт /УВ, Т, ВВ, УФ, ХФ/</i>	

Анхан шатны тэмцээнээс 1 дүгээр байр эзэлсэн баг, тамирчин шигшээ тэмцээнд оролцоно.

#### Тамирчдын тоо /шигшээ тэмцээн/

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
60	60	120

Тайлбар: Шигшээ тэмцээнд шалгаран оролцох тамирчдын нийт тоо

Тэмцээний хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд зохион байгуулна.

Насны хязгаар: 2003 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр төрсөн 19 түүнээс дээш төрсөн тамирчин оролцоно.

Эрх баталгаажих хугацаа: Шигшээ тэмцээнд оролцох тамирчны эрх 2022 оны 06 дугаар сарын 08-13-ны өдрүүдэд баталгаажна.

### 10.14. ТАЕКВОНДО

#### Медалийн тоо /багц/

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
6	6	12
<i>Ганцаарчилсан</i>		
<i>-58кг, -63кг, -68кг, -74кг, -80кг, +80кг,</i>	<i>-46кг, -49кг, -53кг, -57кг, -62кг, +62кг</i>	

Анхан шатны тэмцээнээс 1 дүгээр байр эзэлсэн баг, тамирчин шигшээ тэмцээнд оролцоно.

#### Тамирчдын тоо /шигшээ тэмцээн/

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
120	120	240

Тайлбар: Шигшээ тэмцээнд шалгаран оролцох тамирчдын нийт тоо

Тэмцээний хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 17-19-ний өдрүүдэд зохион байгуулна.

Насны хязгаар: 2005 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр төрсөн 17 түүнээс дээш насны тамирчид оролцоно.

Эрх баталгаажих хугацаа: Шигшээ тэмцээнд оролцох тамирчны эрх 2022 оны 06 дугаар сарын 06-11-ны өдрүүдэд баталгаажна.

### 10.15. ХӨЛ БӨМБӨГ

#### Медалийн тоо /багц/

Эрэгтэй	Бүгд
1	1
<i>Баг 15 тоглогчтой</i>	
<i>Хангайн бүс-3, Төвийн бүс-3, Баруун бүс-3, Зүүн бүс-3, Нийслэл- 4</i>	<i>эрэгтэй16 баг</i>

**Тамирчдын тоо / шигшээ тэмцээн /**

Эрэгтэй	Бүгд
240	240

Тайлбар: Шигшээ тэмцээнд шалгаран оролцох тамирчдын нийт тоо

Тэмцээний хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 14-22-ны өдрүүдэд зохион байгуулна.

Насны хязгаар: 2006 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр төрсөн 16 түүнээс дээш насны тамирчид оролцоно.

Эрх баталгаажих хугацаа: Шигшээ тэмцээнд оролцох тамирчны эрх 2022 оны 06 дугаар сарын 04-10-ний өдрүүдэд баталгаажна.

**10.16. ХӨНГӨН АТЛЕТИК****Медалийн тоо /багц/**

Эрэгтэй	Эмэгтэй	Баг	Бүгд
11	11	4	26
<i>Ганцаарчилсан</i>	<i>Ганцаарчилсан</i>	<i>Буухиа</i>	
<i>100м, 200м, 400м, 800м, 1500м, 5000м, 10000м, уртын харайлт, гурвын харайлт, бөөрөнцөг түлхэлт, зээрэнцэг шидэлт</i>	<i>100м, 200м, 400м, 800м, 1500м, 5000м, 10000м, уртын харайлт, гурвын харайлт, бөөрөнцөг түлхэлт, зээрэнцэг шидэлт</i>	<i>4x100м 4x400м</i>	<i>эрэгтэй 11 зай, эмэгтэй 11 зай, буухиа 2 зай</i>

Анхан шатны тэмцээнээс 1 дүгээр байр эзэлсэн баг, тамирчин шигшээ тэмцээнд оролцоно. 1 тамирчин 2 төрөлд оролцож болно.

**Тамирчдын тоо /шигшээ тэмцээн/**

Эрэгтэй	Эмэгтэй	Баг	Бүгд
240	240	-	480

Тайлбар: Шигшээ тэмцээнд шалгаран оролцох тамирчдын нийт тоо

Тэмцээний хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 15-18-ны өдрүүдэд зохион байгуулна.

Насны хязгаар: 2005 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр төрсөн 17 түүнээс дээш насны тамирчид оролцоно.

Эрх баталгаажих хугацаа: Шигшээ тэмцээнд оролцох тамирчны эрх 2022 оны 06 дугаар сарын 05-10-ний өдрүүдэд баталгаажна.

**10.17. ХҮНДИЙН ӨРГӨЛТ****Медалийн тоо /багц/**

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
7	7	14
<i>Ганцаарчилсан</i>	<i>Ганцаарчилсан</i>	
<i>61кг, 67кг, 73кг, 81кг, 96кг, 109кг, +109кг</i>	<i>49кг, 55кг, 59кг, 64кг, 76кг, 87кг, +87кг</i>	<i>эрэгтэй 7 жин эмэгтэй 7 жин</i>

Анхан шатны тэмцээнээс 1 дүгээр байр эзэлсэн баг, тамирчин шигшээ тэмцээнд оролцоно.

**Тамирчдын тоо /шигшээ тэмцээн/**

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
210	210	42

Тайлбар: Шигшээ тэмцээнд шалгаран оролцох тамирчдын нийт тоо

Тэмцээний хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 15-18-ны өдрүүдэд зохион байгуулна.

Насны хязгаар: 2005 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр төрсөн 17 түүнээс дээш насны тамирчид оролцоно.

Эрх баталгаажих хугацаа: Шигшээ тэмцээнд оролцох тамирчны эрх 2022 оны 06 дугаар сарын 05-11-ний өдрүүдэд баталгаажна.

### 10.18. ЧӨЛӨӨТ БӨХ

#### Медалийн тоо /багц/

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
6	6	12
Ганцаарчилсан	Ганцаарчилсан	
57кг, 65кг, 74кг, 86кг, 97кг, 125кг	50кг, 53кг, 57кг, 62кг, 68кг, 76кг,	эрэгтэй 6, эмэгтэй 6 жин

Анхан шатны тэмцээнээс 1 дүгээр байр эзэлсэн баг, тамирчин шигшээ тэмцээнд оролцоно.

#### Тамирчдын тоо / шигшээ тэмцээн /

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
180	180	360

Тайлбар: Шигшээ тэмцээнд шалгаран оролцох тамирчдын нийт тоо

Тэмцээний хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд зохион байгуулна.

Насны хязгаар: 2004 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр төрсөн 18 түүнээс дээш насны тамирчид оролцоно.

Эрх баталгаажих хугацаа: Шигшээ тэмцээнд оролцох тамирчны эрх 2022 оны 06 дугаар сарын 09-15-ны өдрүүдэд баталгаажна.

### 10.19. ШАТАР

#### Медалийн тоо /багц/

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
1	1	2
Ганцаарчилсан	Ганцаарчилсан	

Анхан шатны тэмцээнээс 1 дүгээр байр эзэлсэн баг, тамирчин шигшээ тэмцээнд оролцоно.

#### Тамирчдын тоо /шигшээ тэмцээн/

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
30	30	60

Тайлбар: Шигшээ тэмцээнд шалгаран оролцох тамирчдын нийт тоо

Тэмцээний хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 17-21-ний өдрүүдэд зохион байгуулна.

Насны хязгаар: 2004 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр төрсөн 18 түүнээс дээш насны тамирчид оролцоно.

Эрх баталгаажих хугацаа: Шигшээ тэмцээнд оролцох тамирчны эрх 2022 оны 06 дугаар сарын 07-12-ны өдрүүдэд баталгаажна.

### 10.20. ШИРЭЭНИЙ ТЕННИС

#### Медалийн тоо /багц/

Эрэгтэй	Эмэгтэй	Баг	Холимог	Бүгд
1	1	2	1	5
Ганцаарчилсан	Ганцаарчилсан	Баг	Хос	
		эрэгтэй, эмэгтэй	холимог	

Анхан шатны тэмцээнээс 1 дүгээр байр эзэлсэн баг, тамирчин шигшээ тэмцээнд оролцоно. тамирчин ганцаарчилсан болон багийн төрөлд оролцож болно.

**Тамирчдын тоо /шигшээ тэмцээн/**

Эрэгтэй	Эмэгтэй	Баг	Бүгд
90	90	30	180

Тайлбар: Шигшээ тэмцээнд шалгаран оролцох тамирчдын нийт тоо

Тэмцээний хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 14-18-ны өдрүүдэд зохион байгуулна.

Насны хязгаар: 2006 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр төрсөн 16 түүнээс дээш насны тамирчид оролцоно.

Эрх баталгаажих хугацаа: Шигшээ тэмцээнд оролцох тамирчны эрх 2022 оны 06 дугаар сарын 04-10-ний өдрүүдэд баталгаажна.

**10.21. ПАРА ЖУДО БӨХ****Медалийн тоо /багц/**

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
4	4	8
<i>Ганцаарчилсан</i>	<i>Ганцаарчилсан</i>	
<i>60кг, 73кг, -90кг, +90 кг,</i>	<i>48кг, 57кг, 70кг, +70кг</i>	<i>эрэгтэй 4 жин, эмэгтэй 4 жин</i>

Тэмцээний хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд зохион байгуулна.

Насны хязгаар: 2006 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр төрсөн 16 түүнээс дээш насны тамирчид оролцоно.

Эрх баталгаажих хугацаа: Шигшээ тэмцээнд оролцох тамирчны эрх 2022 оны 06 дугаар сарын 06-13-ны өдрүүдэд баталгаажна.

**10.22. ПАРА ХӨНГӨН АТЛЕТИК /паралимп төрөл/****Медалийн тоо /багц/**

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
6	5	11
<i>Ганцаарчилсан</i>	<i>Ганцаарчилсан</i>	
<i>T-11; T-12; T-46; T-53, 54-200м, F55, 56, 57; F-40, 41 бөөрөнцөг;</i>	<i>T-11; T12; T-46; T-53, 54-100м; F55, 56, 57 зээрэнцэг; F-40, 41 бөөрөнцөг;</i>	

Тэмцээний хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд зохион байгуулна.

Насны хязгаар: 2006 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр төрсөн 16 түүнээс дээш насны тамирчид оролцоно.

Эрх баталгаажих хугацаа: Шигшээ тэмцээнд оролцох тамирчны эрх 2022 оны 06 дугаар сарын 09-13-ны өдрүүдэд баталгаажна.

**10.23 СУУГАА ВОЛЕЙБОЛ /паралимп төрөл/****Медалийн тоо /багц/**

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
1	1	2
<i>Баг 10 тоглогч</i>	<i>Баг 10 тоглогч</i>	

Тэмцээний хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд зохион байгуулна.

Насны хязгаар: 2006 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр төрсөн 16 түүнээс дээш насны тамирчид оролцоно.

Эрх баталгаажих хугацаа: Шигшээ тэмцээнд оролцох тамирчны эрх 2022 оны 06 дугаар сарын 06-11-ны өдрүүдэд баталгаажна.



#### **10.24. ХОНХОТ БӨМБӨГ /паралимп төрөл/**

##### **Медалийн тоо /багц/**

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
1	1	2
Баг 6 тоглогчтой	Баг 6 тоглогчтой	

Тэмцээний хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 17-19-ний өдрүүдэд зохион байгуулна.

Насны хязгаар: 2006 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр төрсөн 16 түүнээс дээш насны тамирчид оролцоно.

Эрх баталгаажих хугацаа: Шигшээ тэмцээнд оролцох тамирчны эрх 2022 оны 06 дугаар сарын 06-11-ны өдрүүдэд баталгаажна.

#### **10.25. САГСАН БӨМБӨГ /дифлимп төрөл/**

##### **Медалийн тоо /багц/**

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
1	1	2
Баг 10 тоглогч	Баг 10 тоглогч	

Тэмцээний хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 14-22-ны өдрүүдэд зохион байгуулна.

Насны хязгаар: 2006 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр төрсөн 16 түүнээс дээш насны тамирчид оролцоно.

Эрх баталгаажих хугацаа: Шигшээ тэмцээнд оролцох тамирчны эрх 2022 оны 06 дугаар сарын 04-11-ний өдрүүдэд баталгаажна.

#### **10.25. ШИРЭЭНИЙ ТЕННИС /дифлимп төрөл/**

##### **Медалийн тоо /багц/**

Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд
1	1	2
ганцаарчилсан	ганцаарчилсан	

Тэмцээний хугацаа: 2022 оны 06 дугаар сарын 14-22-ны өдрүүдэд зохион байгуулна.

Насны хязгаар: 2006 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр төрсөн 16 түүнээс дээш насны тамирчид оролцоно.

Эрх баталгаажих хугацаа: Шигшээ тэмцээнд оролцох тамирчны эрх 2022 оны 06 дугаар сарын 04-11-ний өдрүүдэд баталгаажна.

#### **АРВАН НЭГ. ГАДААД ОРНУУДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ ИРГЭДИЙН СПОРТЫН ТЭМЦЭЭН**

Монголын бүх ард түмний спортын наадмын хүрээнд сагсан бөмбөг, волейбол, хөл бөмбөгийн спортын төрлүүдээр олон улсын дүрмийн дагуу тэмцээнийг зохион байгуулна.

Монгол Улсаас тухайн улсад суугаа Элчин сайдын яам, консулын газар, тус улсад үйл ажиллагаа явуулдаг спортын төрийн бус байгууллагууд хамтран тэмцээний заавар, удирдамжийг батлан зохион явуулна. Тэмцээний зохион байгуулалтад Элчин сайдын яам, Консулын газраас дэмжлэг үзүүлнэ.

Тэмцээний заавар, удирдамжид зохион байгуулах хот, заал, талбайн байршил, хугацаа, багийн бүрдүүлэлт, зохицуулалт, төсөв, санхүүжилт бусад холбогдох мэдээллийг тодорхой тусгасан байна.

Тэмцээнд оролцогчид нь хот, муж, улсаа төлөөлсөн хэлбэрээр оролцож болно.

Тэмцээнийг зохион байгуулагч комисс, спортын төрийн бус байгууллагаас техникийн зөвлөгөөнийг зохион байгуулна.

Наадмын Зохион байгуулах хорооноос тэмцээн тус бүрд шалгарсан баг, тамирчдыг Монголын бүх ард түмний спортын наадмын медаль, өргөмжлөлөөр шагнах бөгөөд тэмцээнийг зохион байгуулагч комиссоор дамжуулан олгоно.

Тэмцээнд оролцогчид байр, хоол, унааны зардлаа өөрсдөө бүрэн хариуцна.

### **АРВАН ХОЁР.НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР**

Наадам	Монголын бүх ард түмний спортын XV наадам
Салбар зохион байгуулах хороо	Засаг даргын захирамжаар байгуулагдсан аймаг, дүүргийн Зохион байгуулах хороо
Наадмын зохион байгуулах хороо	Биеийн тамир, спортын улсын хорооны даргын тушаалаар байгуулагдсан Зохион байгуулах хороо
Тамирчин	Наадамд оролцох этгээд /сонирхогч, өндөр ур чадвар, мэргэжлийн, лигийн/
Дасгалжуулагч	Тэмцээнд баг, тамирчдыг оролцуулах үйл ажиллагааг удирдаж байгаа этгээд
Ерөнхий шүүгч	Олон улс, улсын цолтой этгээд
Шүүгч	Олон улс, улсын цол, зэрэгтэй тухайн спортын холбооны шүүгч

---oOo---

### **НААДМЫН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО**